

Аудитын код: САГ-2018/03/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: ichinkhorloosh@audit.gov.mn

Аудитор С.Отгонхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn

Гэрээт аудитор Э.Энхбаатар
Утас: 261740 Цахим хаяг: egji0225@yahoo.com

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	3
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	4
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
2.9.1	Үйл ажиллагааны орлогын талаар:.....	5
2.9.2	Үйл ажиллагааны зардлын талаар:	5
2.9.3	Тайлагналын талаар:.....	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	6
2.16	Аудитын үр өгөөжийн тооцоолол	6
3	Менежментийн захидал.....	7
3.1.	орлогын талаар.....	8
3.2.	зардлын талаар.....	9
3.3.	тайлагналын талаар.....	10
4.	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
4.1.	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	11
4.2.	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	12
4.3.	Аудит хийгдсэн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.4.	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.5.	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Д.МӨРӨН ТАНАА

2018.03.23 № 01/809
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд Гадаадын иргэн, харьяатын газрын хэмжээнд төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн, урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн, мөн түрээсийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн засварын материал бэлтгэсэн, бараа материалын эдийн засгийн ангилалыг буруу бүртгэсэн талаар тусгасан.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 3 дугаар сарын 07-нөөс 2018 оны 3 дугаар сарын 16-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 24-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор С.Отгонхорлоо, гэрээт аудитор Э.Энхбаатар нар хариуцан



Аудитаар Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 1-7/470 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Гадаадын иргэн, харьяатын газар нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Монгол улсын Хилийн тухай хууль УИХ-аар батлагдаж тус байгууллагын зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх чиг үүрэг Хил хамгаалах байгууллагад шилжсэнээр Гадаадын иргэн харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, орон тоог Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/24 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын үндсэн үйл ажиллагааны тухай хураангуй:

- Виз бүртгэлийн чиглэлээр

21528 визийн зөвшөөрөл, 25364 виз, 431 гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга, 14727 гадаадын иргэнд Монгол улсад оршин суух зөвшөөрөл тус тус олгож, 25374 гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган оршин суух зөвшөөрөлтэй 17117 гадаадын иргэний бүртгэлд хасалт хийн статус нь өөрчлөгдсөн 174 гадаадын иргэний визний ангилалыг сольсон байна.

- Харьяатын чиглэлээр

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 3 удаагийн зарлигаар 3 улсын 7 иргэн болон харьяалалгүй 1 хүнийг Монгол улсын харьяат болох, 7 удаагийн зарлигаар 553 иргэний Монгол улсын харьяатаас гарч гадаадын 10 улсын харьяат болох асуудлыг шийдвэрлэж, 2 удаагийн зарлигаар 64 иргэний Монгол улсын иргэний харьяалалыг сэргээн тогтоолгож хоёрдмол харьяалал үүсгэсэн 207 иргэнийг бүртгэж, мэдээллийн санд оруулсан. Гадаад улсын 2 гэр бүлд Монгол улсын харьяат 2 хүүхдийг үрчлүүлж, Монгол улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан 4 гэр бүл, гадаадын 6 улсад үрчлэгдсэн 56 хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн санд баяжилт хийсэн байна.

- Хяналт, шалгалтын чиглэлээр

70 удаагийн төлөвлөгөөт, 168 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 1078 аж ахуйн нэгж, байгууллага, 12661 гадаадын иргэнийг хамруулсанаас 1816 гадаадын иргэн, 785 аж ахуйн нэгж, байгууллага (2372 иргэн), 29 уригч иргэн (33 иргэн)-д 93.3 сая төгрөгийн торгууль ногдуулсан. 32 улсын 367 гадаадын иргэн, харьяалалгүй 1 хүн, нийт 368 иргэнийг Монгол улсаас албадан гаргаж, 6 улсын 40 иргэнийг хилээр нэвтрэх эрхийг сэргээж, 14 улсын 108 иргэнийг Монгол улсаас гарахыг түдгэлзүүлж, 19 улсын 205 иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээсэн байна.

Үйл ажиллагааны зорилго:

Байгууллагын эрхэм зорилго нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт нийцсэн нээлттэй, хариуцлагатай үйл ажиллагааг явуулахад чиглэгдэж байна.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

- Төрийн ажил үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад чанартай, шуурхай, хүртээмжтэй, нээлттэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх
- Иргэний харьяалал, цагаачлалын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах



- Монгол улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэдэд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох
- Удирдлагын манлайллыг хангах, хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлох, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг шат дараатайгаар дээшлүүлэх гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Үйл ажиллагаандаа мэдээлэл, технологийн дэвшилтэт техникийг нэвтрүүлэх
- Хяналт-шинжилгээ, дотоод аудит хийж, үр дүнд үнэлгээ өгөх, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагааг тогтмол зохион байгуулж албан хаагчдыг авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах

Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 16 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Гадаадын иргэн, харьяатын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Гадаадын иргэн, харьяатын газар нь санхүүгийн тайлангаа Ординат ХХК-ийн “Unicus” программ хангамжаар бэлтгэсэн байна.


2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналт “хангалттай” байна гэж үзлээ.

2017 онд Гадаадын иргэн, харьяатын газар нь 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 727.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах талаар 19 зөвлөмж өгсөнийг системийн хэмжээнд төлөвлөгөө гаргаж батлуулан тодорхой ажлуудыг зохион байгуулж ажилласаны үр дүнд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2017 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 1-07/1409 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

2017 онд тус байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтөлөлтийг сайжруулах, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг



арилгах, дахин гаргахгүй байх чиглэлээр зөвлөмж, аргачлал гаргаж салбар байгууллагууддаа хүргүүлэн, үр дүнг нь тооцож ажилласан байна. Тухайлбал:

- Төсвийн зарлагыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах,
- Үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд бүртгэлтэй байгаа эд хөрөнгийн дансны ангилал болон нэршил зөрүүтэй хөрөнгийн залруулга хийж, бүртгэх,
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой,
- Үнэт цаасны бүртгэл хөтлөх,
- Шатахуун, тослох материалын бүртгэл хөтлөх,
- Албан хаагчдын хэрэглэж байгаа үндсэн хөрөнгө, бараа материалыг нярваас эд хариуцагч бүрээр картлах, тооллогын дүнг нягтлан бодох бүртгэлийн программд бүртгэх зэрэг 4 аргачлалыг тус тус боловсруулан холбогдох хүснэгт, тооцооллын хамт байгууллагад хүргүүлэн, биелэлтийг тооцож, байгууллагын санхүү бүртгэлийн ажил болон төсвийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэхэд голлон анхаарч ажилласан байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Гадаадын иргэн, харьяатын газар нь 2017 оны Төсвийн тухай хуулиар төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 7 шууд захирагчид 9,410.0 сая төгрөгийн төсөв батлагдсан боловч Хилийн боомтын тухай хууль хүчингүй болж, Монгол улсын хилийн тухай хууль 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан хилийн шалган нэвтрүүлэх чиг үүргийг Хил хамгаалах ерөнхий газар хэрэгжүүлэхэд шаардлагатай 278 орон тоо, ТӨБЗГ-ын 2017 Н/01 тушаалаар 3760 ширхэг 4,380.0 сая төгрөгийн хөрөнгө, 3,760.0 сая төгрөгийг урсгал зардлын төсвийг шилжүүлсэн байна.

Тайлант онд 5,738.1 сая төгрөгийн төсөв батлагдасанаас нийт гүйцэтгэлээр 5,537.9 сая төгрөг буюу 96.5 хувьтай байна. Тайлант онд батлагдсан төсөвт зардлыг 3.5 хувиар буюу 200.1 сая төгрөгөөр хэмнэжээ.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлогыг 12.6 сая төгрөг буюу 52.8 хувиар дутуу төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д төсвийн гүйцэтгэлийн тайланд харуулав.


2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газар нь шилэн дансанд байршуулах мэдээллээ Шилэн данс нэгдсэн портал системийн цахим хуудас <http://www.immigration.gov.mn>, байгууллагын цахим хуудас болон байгууллагын бүх мэдээллүүдийг байршуулан мэдээллийг шинэчлэн Төсөв гүйцэтгэл 9 төрлөөр 854, Хөрөнгө оруулалт тендер худалдан авалт 4 төрлөөр 75, Бусад 4 төрлөөр 54 удаагийн мэдээллийг нийтэд ойлгомжтой ил тод байдлаар байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын уламжлалт болон хяналтын эрсдэлийг 6 чиглэлээр тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 16 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.



2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Үйл ажиллагааны орлогын талаар:

Гадаадын иргэн харьяатын газар 2017 онд батлагдсан үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 12.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь 2017 оны Төсвийн тухай хуулиар баталсан үйл ажиллагааны орлогын хуваарийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөөг биелүүлэх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

2.9.2 Үйл ажиллагааны зардлын талаар:

Тайлант онд бараа материалын зардлын данснаас 26.2 сая төгрөгөөр хөрөнгө бэлтгэж батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

Гадаадын иргэн харьяатын газар нь Дорноговь аймгийн Гадаадын иргэн, харьяатын газрын Төрийн банкний түрээсийн орлого 27,0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтын дансанд төвлөрүүлэн засварын материал бэлтгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны батлагдсан төсөвт зардлыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

2.9.3 Тайлагналын талаар:

Гадаадын иргэн, харьяатын нормын хувцасыг хүнсний материалын дансанд бүртгэж бараа материалын эдийн засгийн ангилалыг буруу бүртгэсэн байна. Тухайлбал: тайлант онд Өмнөд бүс дэхь гадаадын иргэн харьяатын газар нь 26.2 сая төгрөгийн нормын хувцасыг бүртгэлд авахдаа хүнсний материалын зардал буруу тусгасан байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын Буянт-Ухаа дахь салбарын үндсэн хөрөнгийн элэгдлийн эхний үлдэгдэл 0.99 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасан "Үнэн зөв байх" зарчим;

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл: ААНБ санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх гэсэн батламж мэдэгдлийг тус тус хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журмыг дагаж мөрдөх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Гадаадын иргэн, харьяатын салбар байгууллагуудын тэмдэгтийн хураамжийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтэд тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас шалтгаалан Замын үүд сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогоос сумын Засаг даргын нөөц сангаар дамжуулан их хэмжээний хөрөнгө бэлтгэж, харьяа байгууллагууд руу шилжүүлсэн талаар аймгийн Аудитын газраас ирүүлсэн мэдээллийг цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан шалгах боломжгүй байлаа.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Гадаадын иргэн, харьяатын газрын төв, орон нутгийн улсын тэмдэгтийн болон хүү торгуулийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтийг дараагийн аудитаар нарийвчлан шалгах шаардлагатай байна.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 92.0 сая төгрөгийн 5 алдааг залруулах талаар 3 зөвлөмж хүргүүлж байна.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2017 онд Гадаадын иргэн, харьяатын газар нь 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 727.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах талаар 19 зөвлөмж өгсөнийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт албан тоотоор ирүүлсэн байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 12,583,6 сая төгрөг бөгөөд 2 хувиар буюу 251,6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа

2.16 АУДИТЫН ҮР ӨГӨӨЖИЙН ТООЦООЛОЛ

Аудитаар бараа материал, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансанд горим, нарийвчилсан сорил хэрэгжүүлж, аудитын зөвлөмжийг менежментийн захидлаар өгсөн болно.

Гадаадын иргэн, харьяатын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласанаар 53.2 сая төгрөгийн үр өгөөж бий болно гэж тооцлоо.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Гадаадын иргэн, харьяатын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1. ОРЛОГЫН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
----------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Гадаадын иргэн харьяатын газар 2017 онд батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөг 12.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн.

2017 оны Төсвийн тухай хуулиар баталсан үйл ажиллагааны орлогын хуваарийг зөрчсөн.

ҮАГ-ын зөвлөмж

Орлогын төлөвлөгөөг биелүүлэх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулиудын холбогдох заалтууд зөрчигдөх,
Санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламжийн мэдэгдлүүд хангагдахгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2. ЗАРДЛЫН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №2
----------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд бараа материалын зардлын данснаас 26.2 сая төгрөгөөр хөрөнгө бэлтгэж батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Гадаадын иргэн, харьяатын газар нь Дорноговь аймаг дахь Гадаадын иргэн, харьяатын газрын Төрийн банкны түрээсийн орлого 27.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн засварын материал бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 42 дугаар зүйлийн 42.7-д “төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, Холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

Үйл ажиллагааны батлагдсан төсөвт зардлыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор гаргаж ҮАГ-т ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.3. ТАЙЛАГНАЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Гадаадын иргэн, харьяатын нормын хувцсыг хүнсний материалын дансанд бүртгэж бараа материалын эдийн засгийн ангилалыг буруу бүртгэсэн байна. Тухайлбал: тайлант онд Өмнөд бүс дэх Гадаадын иргэн, харьяатын газар нь 26.2 сая төгрөгийн нормын хувцсыг бүртгэлд авахдаа хүнсний материалын зардалд буруу бүртгэсэн байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын Буянт Ухаа дах салбарын үндсэн хөрөнгийн элэгдлийн эхний үлдэгдэл 0.99 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасан “үнэн байх”, Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл: ААНБ санхүүгийн тайланд бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангаагүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журмыг дагаж мөрдөх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор гаргаж ҮАГ-т ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



4. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл**4.1. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган
төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		707,511.90	798,260,1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а,3б	15,940,6	24,405,9
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө		6,868,0	3,163,8
33500	Бусад авлага		520,7	7.2
35	БАРАА МАТЕРИАЛ	8а,8б,8в	689,743,9	773,847,0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		7,342,979,0	5,562,079,1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а,12б,12в	7,342,979,0	5,562,079,1
39200	Биет хөрөнгө		7,323,702,9	5,547,855,9
39300	Биет бус хөрөнгө	13	19,276,1	14,223,2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		8,050,491,0	6,360,339,3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		10,758,5	2,961,9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		10,758,5	2,961,9
41300	Өглөг		4,157,5	612,9
41400	Урьдчилж орсон орлого		6,601,0	2,349,0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		8,039,732,4	6,357,377,4
51	Засгийн газрын хувь оролцоо		8,039,732,4	6,357,377,4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,024,633,7	1,024,633,7
51200	Хуримтлагдсан үр дүн		6,962,507,0	5,280,151,9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		52,591,6	52,591,6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		8,050,491,0	6,360,339,3

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.2. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		17,348,716,6	14,396,939,5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		7,578,226,8	8,638,511,9
120	Нийтлэг татварын бус орлого		7,578,226,8	8,487,414,0
122	Тусламжийн орлого		0	151,097,9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		9,770,489,7	5,758,427,5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2a,2b	16,516,576,9	12,583,690,0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		16,516,576,9	12,583,690,0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		10,739,446,7	6,882,821,7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		6,592,556,8	3,551,187,1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		760,136,8	413,998,0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		316,798,8	225,565,5
2104	Хангамж, бараа материалын зардал		489,285,9	582,003,7
2105	Нормативт зардал		343,569,1	199,065,4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		75,186,4	127,572,7
2107	Томилот, зочны зардал		35,155,0	36,671,3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		650,484,2	289,696,5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,476,273,4	1,457,061,2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,777,130,2	5,700,868,3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		832,139,6	1,813,249,4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		538,184,2	3,498,772,8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		293,955,4	(1,685,523,4)

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.3. Аудит хийгдсэн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,755,562,3	-	7,755,562,3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(9,785,2)	-	(9,785,2)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,745,777,0	-	7,745,777,0
4	Тайлант үеийн үр дүн	293,955,4	-	293,955,4
5	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,039,732,4	-	8,039,732,4
6	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,039,732,5	-	8,039,732,5
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,168,3	-	3,168,3
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,042,900,8	-	8,039,732,4
9	Тайлант үеийн үр дүн	(1,685,523.4)	-	(1,685,523.4)
10	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,357,377.4	-	6,357,377.4

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.4. Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган
төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		15,215,621,8	11,064,259,3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		5,445,105,1	5,289,513,6
120	Нийтлэг татварын бус орлого		5,445,105,1	5,289,513,6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		9,770,516,7	5,774,745,6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		15,194,237,4	11,029,186,1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		15,194,237,4	11,029,186,1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		9,303,914,5	5,306,699,6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		6,601,177,8	3,550,343,3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		756,954,3	413,309,7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		287,212,8	225,383,0
2104	Хангамж, бараа материалын зардал		326,566,7	312,113,3
2105	Нормативт зардал		249,497,7	247,277,3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		115,196,3	133,362,2
2107	Томилолт, зочны зардал		35,661,6	36,671,3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		682,775,1	247,794,7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		248,871,8	140,444,4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,890,322,8	5,722,486,4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		21,384,4	35,073,2
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		14,575,3	26,607,9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		14,575,3	26,607,9
2200	Дотоод эх үүсвэрээр		14,575,3	26,607,9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(14,575,3)	(26,607,9)
VI	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		6,809,1	8,465,3
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		9,131,4	15,940,6
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		15,940,6	24,405,9

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,738,145,9	5,537,998,8	200,147,0	96.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,738,145,9	5,537,998,8	200,147,0	96.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,452,128,4	5,283,036,2	169,092,1	96.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,695,511,2	3,550,343,3	145,167,8	96.1
210101	Үндсэн цалин	2,402,856,0	2,339,984,8	62,871,1	97.4
210102	Нэмэгдэл	858,585,7	820,166,9	38,418,7	95.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	434,069,5	390,191,6	43,877,8	89.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	441,586,4	413,309,7	28,276,6	93.6
210201	Тэтгэврийн даатгал	277,648,9	266,040,5	11,608,3	95.8
210202	Тэтгэмжийн даатгал	35,366,6	34,216,8	1,149,7	96.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	36,237,7	30,222,2	6,015,4	83.4
210204	Ажилгүйдлийн даатгал	7,973,4	8,836,7	(863,3)	110.8
210205	Эрүүл мэндийн даатгал	84,359,8	73,993,4	10,366,3	87.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	230,793,8	225,383,0	5,410,7	97.7
210301	Гэрэл, цахилгаан	76,947,9	74,279,5	2,668,3	96.5
210302	Түлш, халаалт	51,814,1	50,706,6	1,107,4	97.9
210303	Цэвэр, бохир ус	17,960,7	17,245,5	715,1	96.0
210304	Байрны түрээс	84,071,1	83,151,3	919,7	98.9
2104	Хангамж, бараа материалын зардал	300,568,4	304,366,2	(3,797,8)	101.3
210401	Бичиг хэрэг	42,589,9	42,178,5	411,3	99.0
210402	Тээвэр, шатахуун	149,757,2	154,595,0	(4,837,8)	103.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	48,994,7	47,582,3	1,412,3	97.1
210404	Ном, хэвлэл	2,896,4	2,891,3	5,1	99.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	56,330,2	57,119,0	(788,8)	101.4
2105	Нормативт зардал	247,517,5	247,277,3	240,1	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	247,517,5	247,277,3	240,1	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	91,514,2	91,218,0	296,1	99.7
210604	Урсгал засвар	91,514,2	91,218,0	296,1	99.7
2107	Томилолт, зочны зардал	37,056,9	36,671,3	385,5	99.0
210702	Дотоод албан томилолт	37,056,9	36,671,3	385,5	99.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	279,276,8	273,644,7	5,632,0	98.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	180,260,2	175,140,7	5,119,4	97.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,0	2,500,0	0,0	100,0
210803	Даатгалын үйлчилгээ	6,930,0	6,903,0	27,0	99,6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,564,0	2,402,2	161,8	93,7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	52,400,6	52,386,2	14,3	100,0
210807	Газрын төлбөр	1,676,0	1,572,4	103,6	93,8

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	32,946,0	32,740,2	205,8	99.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	128,303,2	140,822,4	(12,519,2)	109.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,810,2	92,364,6	(12,554,4)	115.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,493,0	48,457,8	35,1	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	286,017,5	254,962,5	31,054,9	89.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	286,017,5	254,962,5	31,054,9	89.1
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	43,906,8	43,513,9	392,8	99.1
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	149,110,7	139,865,6	9,245,0	93.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	93,000,0	71,583,0	21,417,0	77.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,738,145,9	5,725,467,2	12,678,6	99.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,714,145,9	5,714,145,9	0.0	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	5,714,145,9	5,714,145,9	0.0	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	24,000,0	11,321,3	12,678,6	47.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,000,0	11,321,3	12,678,6	47.2
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	627.0	585.0	42.0	93.3
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	7.0	7.0	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	7.0	7.0	0.0	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.0	0.0	0.0	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	310.0	289.0	21.0	93.2
620001	Удирдах ажилтан	2.0	2.0	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	226.0	200.0	26.0	88.5
620003	Үйлчлэх ажилтан	82.0	87.0	-5.0	106.1
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	310.0	289.0	21.0	93.2
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	228.0	207.0	21.0	90.8
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.0	1.0	0.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	81.0	81.0	0.0	100.0

